

Сургалтыг Дэмжих Эрчимжүүлсэн COVID Хөтөлбөр

Эцэг эх болон асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл

Сургалтыг Дэмжих Эрчимжүүлсэн COVID Хөтөлбөрийн тухай

Сургалтыг Дэмжих Эрчимжүүлсэн COVID Хөтөлбөр (COVID Intensive Learning Support Program (CILSP)) нь NSW мужийн бага, дунд болон тусгай гүнзгийрүүлсэн сургуульд сурдаг, ийм төрлийн сургалт хамгийн их хэрэгцээтэй байгаа сурагчдад зориулсан жижиг бүлгийн сургалт юм.

Энэхүү хөтөлбөрийг NSW мужийн Боловсролын Яам, NSW мужийн Католик Сургуулиуд болон NSW мужийн Хувийн Сургуулиудын Нийгэмлэг хамтран хэрэгжүүлж байгаа юм.

Уг хөтөлбөрийг COVID-19-н тархалтын улмаас урт хугацаагаар гэрээсээ суралцсан нь сурлагад нь сөргөөр нөлөөлсөн сурагчдад туслах зорилгоор хэрэгжүүлж эхэлсэн юм. Хөтөлбөрийн агуулга нь бичиг үсэг болон тооны хичээлд төвлөрөн явагддаг.

Сургууль бүр сурагчдынхаа хэрэгцээнд нийцүүлэн өөрсдийн хөтөлбөрийг боловсруулах бөгөөд тусгай сургагдсан багш нар, их сургуулийн лектор, сургуулийн өмнөх боловсролын багш нар зэрэг сурган хүмүүжүүлэгчдийг ажиллуулан уг хөтөлбөрийг удирдан зохион байгуулна. Эдгээр жижиг бүлгийн сургалтууд нь хичээлийн өмнө, дараа, эсвэл хичээлийн цагаар явагдаж болно.

Хөтөлбөр хэрхэн явагдах вэ?

Сургалтыг дэмжих эрчимжүүлсэн COVID хөтөлбөрийн хүрээнд сурагчдад зориулсан жижиг бүлгийн сургалт явуулахад нь нэмэлт багш нарыг ажиллуулах зорилгоор сургуулиудад нэмэлт санхүүжилт олгогдох болно.

Ангийн багш нар нь сургуулийн захиралтай хамтран, мөн төрөл бүрийн үнэлгээний аргыг ашиглан аль хүүхэд энэхүү жижиг бүлгийн сургалтанд хамрагдах хэрэгцээтэй байгааг тодорхойлно.

Дараа нь хөтөлбөрт хамрагдах талаар хүүхэд бүрийн эцэг эх, асран хамгаалагчтай нь ярилцаж сургалтын төлөвлөгөөг боловсруулна. Хүүхдийн сургалтын явцыг тогтмол хянах бөгөөд эцэг эх, асран хамгаалагчтай байнгын холбоо тогтоох болно.

Хөтөлбөрийн үндсэн мэдээлэл

- Энэхүү хөтөлбөрт NSW мужийн улсын сургуулийн аль ч сурагч хамрагдаж болох бөгөөд 2021 онд нийт 265,000 сурагчид хөтөлбөрт хамрагдсан болно.
- Жижиг бүлгийн сургалтыг цагийн болон түр багш нар, тэтгэвэрт гарсан багш нар, ангийн багш нар зэрэг нэмэлт багш нар явуулах болно. Уг нэмэлт багш нар нь сургалтыг тухайн сурагчын хэрэгцээнд тохируулахын тулд ангийн багштай нь нягт хамтран ажиллах болно.
- Хөтөлбөрийн агуулга нь бичиг үсэг болон тооны хичээлд төвлөрөн явагдана.

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мэргэшсэн сургагчид болон зохион байгуулагчид сургуулиудад дэмжлэг үзүүлэн, зааварчлах болно.
- Жижиг бүлгийн сургалт нь 2-5 сурагчдаас бүрдсэн бүлэгт нэмэлт сургалт орох мөн сурах явцад нь дэмжлэг үзүүлэх болно. Танхимд үзсэн хичээлүүдийг бататгах зорилгоор уг бүлгийн сурагчид урьдчилж заасан хугацаагаар тогтмол хичээллэх болно.

Сургалтыг Дэмжих Эрчимжүүлсэн COVID Хөтөлбөр болон таны хүүхэд

Хэрвээ багш нь таны хүүхдийг энэхүү хөтөлбөрт хамрагдах хэрэгцээтэй гэж үзвэл тантай холбогдох болно.

Та уг хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Сургалтыг Дэмжих Эрчимжүүлсэн COVID Хөтөлбөр ([COVID Intensive Learning Support Program webpage](#)) цахим хуудсаар орж танилцана уу. Хэрвээ та нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл хүүхдийнхээ багштай нь энэхүү хөтөлбөрийн талаар ярилцаарай.

Утсан Орчуулгын Үйлчилгээ

Хэрвээ танд нэмэлт мэдээлэл хэрэгтэй бол сургуулийн захиралтай утсаар холбогдоорой. Таны ярианд орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт холбогдон өөрийн хэл дээрх орчуулагчийг хүснэ үү. Операторт холбогдохыг хүссэн утасны дугаараа хэлэхэд оператор таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.